



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№109 /109/

2021.08.10

ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ БХЯ, ЗХЖШ-Т АЖИЛЛАЖ БАЙНА



Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх БХЯ, ЗХЖШ-т ажиллаж байна. Түүнийг дагалдаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо болон бусад албаны хүмүүс ажилласан юм. Энэ үеэр тэрээр "Батлан хамгаалах бодлого, зорилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар танилцуулж, харилцан ярилцлаа.

Мөн Зэвсэгт хүчний зэвсэглэлд шинээр нэвтрүүлсэн болон гадаадын тусламжаар авсан зэвсэглэл, техниктэй танилцаж, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад үүрэг гүйцэтгэсэн Цэргийн багуудын бие бүрэлдэхүүнд төрийн одон, медаль гардуулах юм.

ҮБХИС-ИЙН 91 ДЭХ УДААГИЙН ТӨГСӨЛТ БОЛЛОО



Монгол Улсын боловсролын ууган байгууллага, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 91 дэх удаагийн төгсөлийн ёслолын арга хэмжээ өчигдөр тус сургуулийн хэргийн сургалтын төвд боллоо. Энэ удаагийн төгсөлт нь Монгол Улсын Батлан хамгаалах яам үүссэний 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулгасны 100, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 100 жилийн тэгш ой тохиосон түүхэн цаг үед болж байгаагаараа онцлог юм. Төгсөлтөөр ҮБХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академи, Цэргийн нэгдсэн дээд сургууль, Цэргийн хөгжмийн коллеж, Батлан хамгаалахын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нийт 300 гаруй залуус цэргийн мэргэжлийн боловсролын диплом, энгэрийн тэмдгээ гардан авсан юм. Ёслолын ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал тэргүүтэй албаны хүмүүс оролцлоо.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр төгсөгчдөд хандаж хэлсэн үгэндээ "Монгол Улсын Зэвсэгт хүчин, цэрэг эрс маань улс орноо батлан хамгаалах

хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүргийг амжилттай гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд идэвхийлэн оролцож, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өндөрт өргөж байна. Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагч болно гэдэг нь цэргийн дүрэмт хувцас, цолны төлөө биш, харин эрдэм мэдлэг, ажил алба, цэргийн мэргэжил, Зэвсэгт хүчин, эх орныхоо төлөө байж, цэргийн хөдөлмөр, цэргийн амьдралын утга учир нь болж, Эх орноо батлан хамгаалах үйл хэрэг, ард түмэн, төрийнхөө өмнө өргөсөн цэргийн тангарагтаа чин үнэнчээр зүтгэж, өмнөө тавигдсан үүргээ нэр төртэйгөөр мадаггүй биелүүлэхэд л оршиж байдаг юм. Иймээс та бүхэнд Монгол цэргийн сүлд хийморь, нэр төрийг дээдлэн хүндэтгэж, өргөсөн цэргийн тангарагтаа чанд сахин биелүүлж, даян дэлхийн энхийн үйлс, эх орныхоо тусгаар тогтнолын төлөө сурсан эрдэм мэдлэг, сэтгэл оюунаа бүрэн зориулж ажиллахыг хүсэн ерөөж, төгсөгчид та бүхэнд дахин баяр хүргэж, амжилт хүсье" гэв.

ҮБХИС нь сургалтын үр дүнг эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, далайцыг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн цэргийн мэргэжлийн бакалаврын 4 жилийн хөтөлбөрийн тогтолцоонд шилжих, түүнчлэн сургалтын хөтөлбөрийг орчин үед тавигдаж буй шаардлагад нийцүүлэн шинэчлэлт хийхээр төлөвлөн ажиллаж байгаа аж.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.851.0
EUR 🇪🇺	3.38.0	3.395.0
CNY 🇨🇳	441.5	442.5
RUB 🇷🇺	38.40	39.60
JPY 🇯🇵	25.85	26.40
KRW 🇰🇷	2.43	2.53

ЗУРХАЙ

2021.08.10 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 2/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БАР ӨДӨР

Үс засуулбал:

Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх:

05:41-20:15

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Арвидах

Суудал:

Авахуй

Энэ өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 174.603 +1073	ЭДГЭРСЭН 155.805 +1811	НАС БАРСАН 857 +5
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4239 +78	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 151 +17	ЭДГЭРСЭН 4006 +48
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 204,096,177
Эдгэрсэн Нийт: 183,274,529
Нас барсан Нийт: 4,315,463

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛААРХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрх, нус гоожих
- Булчин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавиурх, идрах

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

ЦАХИМ ШУУДАНД

ДЭЛХИЙН ААВУУДЫН ӨДӨРТ...

Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Өнгөрсөн амралтын өдрүүдээр Сүхбаатар дүүргийн ЗДТГ-н Цэргийн штабаас Зэвсэгт хүчний 186, 311 дүгээр ангиуд болон дүүргийн хороодтой хамтран

хугацаат цэргийн алба хааж байхдаа аав болсон дайчдыг ар гэртэй нь уулзууллаа. Энэ хүрээнд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид алба хааж байгаа байлдагч Н.Дашчойлонтай эхнэр, хүүхдийг нь уулзуулан,

Зэвсэгт хүчний 186 дугаар ангид хугацаат албаа хааж байхдаа аав болсон байлдагч Б.Тэлмэнг эхнэр хүүхэдтэй нь цахимаар уулзуулж, дайчдын ар гэрт хүнсний багц, гарын бэлэг өглөө.



Байлдагч Н.Дашчойлон: ЭХНЭР, ОХИНТОЙ МИНЬ УУЛЗУУЛЖ ГЭНЭТИЙН БЭЛЭГ БАРЬСАНД МАШ ИХ БАЯРТАЙ БАЙНА

-Би Нийслэлийн Сүхбаатар дүүргээс 2020 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид татагдан ирсэн.

Дэлхийн аавуудын баярын өдрийг тохиолдуулан Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас эхнэр, охинтой минь уулзуулж гэнэтийн бэлэг барьсанд маш их баяртай байна. Ирнэ гэж хэлээгүй болохоор юу ч мэдээгүй. Үнэхээр гэнэтийн байлаа. Ковидтой байхад охиноо харж уулзаж чадахгүй нь дээ гэж бодож байтал өнөөдөр хүрээд ирлээ. Сэтгэгдэл маш өндөр, аз жаргалтай байна. Дүүргийнхээ Цэргийн штабын хамт олонд маш их баярлалаа.



Байлдагч Б.Тэлмэн: ТЭР ЗАХИАНД ХОРВООГИЙН БҮХИЙ Л САЙХАН ЗҮЙЛСИЙГ ХАМААД БИЧЧИХСЭН



хорвоогийн бүхий л сайхан зүйлсийг хамаад биччихсэн байсан. Тэр нь миний аав болсон тухай болоод миний бяцхан охины зураг юм. Аав болсноо мэдээд туйлын их баярлаж, баярласандаа уйлсан. Тэгээд охиндоо Энхлэн гэж нэр өгсөн.

Энэ өдрөөс хойш би аав болсон хүн алдах эрхгүй гээд албаа хамгийн сайнаараа хаахыг хичээж, охиндоо очих өдрийг тэсэн ядан хүлээж байна. Энэ завшааныг ашиглаад хорвоод намайг ааваа гэж дуудах үрийг минь төрүүлж өгсөн хайртай ханьдаа баярлалаа гэж хэлмээр байна. Чамдаа бас охиндоо хамгаас илүү хайртай шүү.

-Би 2020 оны II ээлжийн хугацаат цэргийн татлагаар Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргээс Зэвсэгт

хүчний 186 дугаар ангид алба хаахаар ирсэн. Цэргийн албанд ирээд хорьхон хоноод захидал авлаа. Энэ захианд

Байлдагч А.Пүрэвбалжир: ХҮҮТЭЙ БОЛСНОО МЭДСЭН ТЭР МӨЧИД ӨӨРИЙН ЭРХГҮЙ СЭТГЭЛ ДОГДЛОН, ЗҮРХ ХУРДАН ЦОХИЛЖ, НҮДНЭЭС НУЛИМС ГАРААД Л ...



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Би Архангай аймгийн Хайрхан сумаас 2020 оны II ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний 186 дугаар ангид хугацаат цэргийн албыг хаахаар ирсэн. Цэргийн

албанд өөрийн хүсэлтээр ирсэн бөгөөд цаашдаа төрийн албанд хүчин зүтгэж улс эх орондоо өөрийн хувь нэмрээ оруулах хүсэлтэй явна. Цэргийн албанд ирж олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэн, жагсаалын алхаагаар

алхаж, оройн зугаалгын дуу гарган цуурайтуулж явахад өөрийн эрхгүй сэтгэл зүрх минь огшдог. Ийм л сайхан дурсамж, ийм л сайхан мөчүүд өнгөрч байна.

Хайрт хань минь Архангай аймгийн үзэсгэлэнтэй эмэгтэй Б.Хорлоо гэж бүсгүй байдаг. Бид хоёр нэг гэрт амьдраад 4 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд хань минь надад Балжинням гэх хөөрхөн бяцхан удам залгах хүү төрүүлж өгсөн. Хүүтэй болсноо мэдсэн тэр мөчид өөрийн эрхгүй сэтгэл догдлон, зүрх хурдан цохилж, нүднээс нулимс гарсныг сүүлд мэдсэн юм. Өөртөө аав боллоо шүү гээд л ойр ойрхон амандаа хэлж, хэцүү үед хүүгээ бодож сэтгэл зүрхээ чангалан явна.

Би бөхийн удамтай учраас хүүгээ багаас нь бөхийн секцэнд хичээллүүлж мундаг том бөх болгоно оо. Аав болгосон ханьдаа хайртай шүү.

Байлдагч Б.Аминдиваа: МИНИЙ АМЬДРАЛЫН ХАМГИЙН АЗ ЖАРГАЛТАЙ МӨЧ

-Би 2020 оны II ээлжийн цэрэг татлагаар Хөвсгөл аймгийн Жаргалант сумаас Зэвсэгт хүчний 186 дугаар ангид хугацаат цэргийн албанд татагдсан.

Би айлын 2 дахь хүүхэд, анх цэргийн албыг их хатуу ширүүн чанга гэж бодож явлаа. Байдал огт өөр байгаад баяртай байна. Би өөрийгөө өөрчлөх гэж өөрийн хүсэлтээр хугацаат цэргийн албанд ирсэн.

Цэргийн албанд ирээд 6 сарын дараа миний охин Хишигдалай хорвоод мэндэлж аав гэж дуудах нэрийг надад хайрласан. Ингээд миний толгойд хамгийн түрүүнд эцэг хүний үүрэг хариуцлага гэдэг зүйл орж ирлээ. Ийм учраас эр хүний үүрэг, эх орны хүү, эцэг хүн болсон учир эр цэргийн албаа нэр төртэй хааж, эх нутаг, ээж, аав, эхнэр хүүхдэдээ нэр төртэй очно.

Миний ханийг Х.Хонгорзул гэдэг. Чамайгаа уурлуулж гомдоож байсанд


уучлаарай. Удахгүй гурвуулаа аз жаргалтай, сайхан амьдрах цаг мөч тун удахгүй ирнэ.



Байлдагч О.Төрхуяг: ААВ БОЛСОН ГЭДЭГТЭЭ ОДОО Ч ИТГЭЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

-Би Эрдэнэт хотын уугуул. Аймагтаа цэргийн алба хааж байгаадаа туйлын их баяртай байна. Би эхнэр О.Нандин-Эрдэнэтэй танилцаад нэг жилийн өмнө гэрлэлтээ батлуулсан. Хань минь намайг цэрэгт ирээд 4 сарын дараа охин Нандинхоролыг минь төрүүлсэн. Охиноо ямар хүүхэд байгаа бол хэнтэй адилхан бол гээд онжавууддаа яриад л. Одоо цэргээс халагдаж очоод охиноо аав нь гэж хэлж дасахгүй ах ах нь гээд дуудах байхдаа. /Инээв/ Эхнэр бид хоёрт алсдаа хөдөө аж ахуйн бизнес эрхэлнэ гэж бодож байгаа. Цэргээс халагдаж очоод бодсон зүйлээ хэрэгжүүлж эхэлнэ дээ.

Би цэрэгт ирээд цэргийн албанаас гадна сэтгэл зүйн хувьд болоод хүнтэй харьцах



харилцаа, хамт олны дунд биеэ авч явах талаар их зүйл сурлаа. Одоо цэргээс халагдахад 2 сарын хугацаа үлдсэн. Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн удирдлага,

хамт олондоо их зүйлийг зааж сургасанд баярлалаа, ажлын өндөр амжилт хүсье. Баярлалаа.

Хошууч Т.Заяандарь